

**ХАРИЛЦАН ВИЗЭЭС ЧӨЛӨӨЛӨХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ХОНКОНГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас энэхүү хэлэлцээрийг байгуулах бүрэн эрх олгосны дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хонконгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэх/,

хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, Монгол Улс, БНХАУ-ын Хонконгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн хооронд иргэд харилцан зорчих нөцөлийг хөнгөвчлөх зорилгоор,

дор дурдсан зүйлийг харилцан тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

1. Монгол Улсын хүчин төгөлдөр дипломат, албан, энгийн гадаад паспорттай иргэд БНХАУ-ын Хонконгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн нутаг дэвсгэрт 14 хүртэл хоногийн хугацаагаар орох, гарах, дамжин өнгөрөх тухай бүрд виз авахаас чөлөөлөгдөнө.

2. БНХАУ-ын Хонконгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн хүчин төгөлдөр паспорттай иргэд 14 хүртэл хоногийн хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орох, гарах, дамжин өнгөрөх тухай бүрд виз авахаас чөлөөлөгдөнө.

3. Энэхүү Хэлэлцээрийн 1, 2 дугаар зүйлд дурдсан хүчин төгөлдөр паспорттай иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 14 хоногоос илүү хугацаагаар байх бол визийг урьдчилан авна. Хэлэлцэн тохирогч Талуудын төрийн албан хаагчид албан хэргээр зорчиход холбогдох эрх бүхий байгууллагын албан захидлыг үндэслэн хураамжгүй виз олгоно.

Хоёрдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан аль нэг Хэлэлцэн тохирогч Талын хүчин төгөлдөр паспорттай иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, гарах болон дамжин өнгөрөхдөө Хэлэлцэн тохирогч нөгөө Талын олон улсын зорчигчдод нээлттэй хилийн боомтоор нэвтрэнэ.

2. Хэлэлцэн тохирогч нэг талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суухдаа холбогдох хууль, тогтоомжийг сахин биелүүлэх үүрэгтэй.

3. Энэхүү Хэлэлцээр нь тааламжгүй гэж үзсэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийг нутаг дэвсгэртээ оруулахаас буюу байх хугацааг богиносгох Хэлэлцэн тохирогч аль нэг Талын бүрэн эрхийг хөндөхгүй.

Гуравдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр зорчих баримт бичгийн загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг тал энэхүү Хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаанд зорчих баримт бичигт өөрчлөлт оруулсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа түүний загварыг хэрэглэж эхлэхээс 30 хоногийн өмнө дипломат шугамаар хүргүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нийгмийн хэв журмыг эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийм арга хэмжээ авсан болон дуусгавар болсон тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэж байна.

Тавдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулсан бөгөөд Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Хэлэлцэн тохирогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухайгаа 60 хоногийн өмнө дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

Энэхүү Хэлэлцээрийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хонконгийн Засаг Захиргааны Онцгой Бүсэд 1998 оны 6 дугаар сарын 18-ны өдөр англи хэлээр хоёр хувь байгуулав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ХОНКОНГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ
ОНЦГОЙ БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг